



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
Э.БАТШУГАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2026.05.28 № 29

Эмнэлгүүдийн цалингийн сан, эрүүл  
мэндийн даатгалын санхүүжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, ажилчид болон ахмад настнуудын зүгээс ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн дараах асуултыг тавьж байна.

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны 01 дүгээр тогтоол Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 3 дугаар сарын 24-ний өдөр бүртгэгдсэн боловч хэрэгжиж эхлэх хугацаа тодорхойгүйгээс анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилт хуучин тарифаар олгогдож, өглөг үүссэн-асуудлыг хэзээ, хэрхэн шийдвэрлэх талаар;

2. Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлж буй аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүд, төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд нь оношийн хамааралтай бүлгээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг. Гэтэл уг оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, холбогдох журмыг зохицуулж буй Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолыг өнөөдрийг хүртэл шинэчлэн батлаагүй байгаа шалтгаан, хэрэгжилт саатсан үндэслэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

3. 2026 оны эхний 5 сарын байдлаар эмнэлгүүд санхүүжилтийн эх үүсвэр талдаа цалингийн 30 хувийн өсөлт ороогүй тарифаар Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж, зарлага талдаа 30 хувь нэмэгдүүлсэн үндсэн цалинг олгож байгаагаас ихээхэн хэмжээний өглөг үүссэн байна. Эмнэлгүүд эм, хоол болон бусад зардлыг гэрээт байгууллагуудад өглөг үүсгэж, байгаа төсөвтөө цалингаа тавих арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар асуудал тавьж байна. Иймд цалингийн нэмэгдлээс үүссэн зөрүү дүнг эмнэлэг тус бүрээр гаргаж, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар;

4. Миний бие Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллаж байх хугацаанд буюу 2022 онд эрүүл мэндийн байгууллагуудаас тусламж, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтыг анх удаа явуулж, сонгон шалгаруулалтын үр дүнгээр 3 жилийн хугацаатай гэрээ байгуулж ажилласан. Дараагийн сонгон шалгаруулалтыг явуулсан эсэх, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт орж байгаа эсэх;

᠑᠙᠑᠐᠐᠐᠑᠑᠑᠑

5. Улсын Их Хурлын даргын 95 дугаар захирамжаар байгуулагдсан “Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж, ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн болон ахмадын цогц тусламж, үйлчилгээний асуудлаар санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий” ажлын хэсгийг миний бие ахлан ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хэсгийн хүрээнд ахмад настуудаас ирүүлсэн санал, хүсэлтэд үндэслэн ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тулгамдсан асуудал, цаашдын арга хэмжээний талаар дараах мэдээлэл:

5.1. Ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэхэд 2025, 2026 онд улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгал болон бусад эх үүсвэрээс батлагдсан санхүүжилтийн хэмжээ, бодит зарцуулалтын талаарх мэдээлэл;

5.2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-д өөрчлөлт орох эсэх, уг журмын хэрэгжилтийг хангах хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, халамжийн байгууллагын ажилтнуудыг сургасан байдал, хамрагдсан хүний тоо, зохион байгуулалтын талаарх мэдээлэл;

5.3. Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад тулгамдаж буй хүндрэл, тухайлбал, хүний нөөц, санхүүжилт, үйлчилгээний хүртээмж, орон нутгийн ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэгжилтийн талаар;

5.4. Цаашид ахмад настанд үзүүлэх цогц тусламж, үйлчилгээ болон урт хугацааны асаргааны тогтолцоог сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардлагатай хууль, эрх зүйн актад оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЭРДЭНЭБАТ

᠑᠒᠒᠖᠐᠐᠗᠐᠐᠔